

**“ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ТӨГСГӨЛИЙН ШАТНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017оны 3 дугаар сарын 29

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл		
1.	“Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” хөтөлбөр /2014-2016/, Засгийн газрын 2014-08-28-ний өдрийн 278 дугаар тогтоол	Хөтөлбөрийн зорилго: Хөтөлбөрийн зорилго: Жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг бий болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд оршино.		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр байхгүй батлагдсан .	<ul style="list-style-type: none"> ➢ Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө; ➢ Засгийн газрын бонд; ➢ Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө ➢ Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө ➢ Орон нутгийг хөгжүүлэх тусгай сангийн хөрөнгө; ➢ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө; ➢ Инновацийг дэмжих сангийн хөрөнгө; ➢ Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө; ➢ Олон улсын болон хандивлагч орнуудын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт; ➢ Бусад эх үүсвэр. 		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Аж үйлдвэрийн яам Хэрэгжүүлэх хугацаа 2014-2016 он Тус хөтөлбөр нь 2014оны 08 дугаар сараас 2016 он 6 сар хүртэл буюу 28 сарын хугацаанд хэрэгжсэн байна.</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Бусад яамдууд, орон нутгийн ЗДТГазар, ТББ-ууд</p>		
	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1. Хууль, эрх зүйн орчныг сайжруулах;</p> <p>Зорилт 2. Кластераар хөгжүүлэх;</p> <p>Зорилт 3. Судалгаа боловсруулалт болон инновацийг хөгжүүлэх;</p> <p>Зорилт 4. Жижиг, дунд үйлдвэрийг чадавхижуулах;</p> <p>Зорилт 5. Санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүртээмжийг хангах;</p> <p>Зорилт 6. Зах зээлийг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх.</p>		
5.	Зардал	Төсөв (Нийт шаардагдах зардал)		
		Үүнд:	Төсөв /2014-2016/	Гүйцэтгэл
	Улсын төсөв (Аж үйлдвэрийн яам)	88225000	100	Улсын төсөвөөс эх үүсвэртэй 88 225 000 сая төгрөгийг 100 хувь зарцуулсан.
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:			

<p>Зорилт 1.Хууль, эрх зүйн орчныг сайжруулах;</p> <p>Хүрэх үр дүн: -Жижиг, дунд үйлдвэрийн талаар шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, хөтөлбөр, төлөвлөгөө, журмын хэрэгжилтийн явц сайжирсан байна.</p>	<p>1.1.Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p> <p>❖ Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 08 тоот тушаалаар байгуулан, салбарын яамд, мэргэжлийн холбоодоос санал аван, үзэл баримтлалыг Засгийн газрын 2015-03-24 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Хууль зүйн сайд болон Аж үйлдвэрийн сайдаар батлуулан, хуулийн төслийг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилтээр ажиллаж буй хуульч, судлаачийн тусламжтайгаар боловсруулсан. Засгийн газрын 2016 оны бүтцийн өөрчлөлттэй холбогдон Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яманд Жижиг, дунд үйлдвэрийн асуудал харъяалагдах болж тус хуулийг дахин шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд 2017 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ: 30</p> <p>1.2.Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</p> <p>❖ “Хоршооны тухай хуулийн шинэчилсэн төслийг боловсруулсан. Хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2014-10-20-нд Глобал коммунити төсөл, хоршоодын холбоодын оролцоотой хамтран зохион байгуулсан.</p> <p>❖ Засгийн газрын 2016 оны бүтцийн өөрчлөлттэй холбогдон Аж үйлдвэрийн яам татан буугдаж Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яманд Жижиг, дунд үйлдвэрийн асуудал харъяалагдах болж Хоршооны тухай хуулийг дахин шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2016 оны А/43 тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг дахин хуулийн төсөл дээр ажиллаж 2017 онд Улсын Их хуралд өргөн мэдүүлнэ.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ: 30</p> <p>1.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хүртэл хувийг буцаан олгох буюу чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх;</p> <p>❖ 2015 оны 7 дугаар сард Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 13.6 “д “Жилийн 50 саяас доош төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ борлуулсан этгээд /импортоор оруулахаас бусад/-ийг албан татвараас чөлөөлнө” гэж заасан. Энэ нь нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэх босго 10 сая төгрөг байсныг 50 сая төгрөг болгосон.</p> <p>❖ Нийслэл хотоос 600 км, 1000 км алслагдсан аймгийн аж ахуй нэгжийн Аж ахуй нэгжийн оролгын албан татварыг 50%, 90% -иар хөнгөлөхтэй холбоотой Аж ахуй нэгжийн оролгын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж 2016-02-05-ны өдрийн хуралдаанаар баталсан.</p> <p>❖ Аж ахуй нэгжийн орлогын албан татвар, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төслүүдийг УИХ-ын 2016 оны хаврын нэгдсэн чуулганаар анхны хэлэлцүүлэг хийгдсэн.Уг хуулийн төсөлд Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн татварын тайланг хялбаршуулан тайлагнах зарчмаар, төлсөн татварын 90 хувийг буцаан олгох буюу татварын хувь хэмжээг 1% болгох, тайлагналын тоог бууруулахаар тусгасан бөгөөд хаврын чуулганаар энэ асуудал шийдвэрлэгдээгүй болно.</p> <p>❖ Шинэ засгийн газраас УИХ-д 2016-09-30-ны өдөр өргөн барьсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд</p>
--	--

		<p>нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд тодорхой салбарт үйл ажиллагаа явуулж буй 1,5 тэрбум төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуй нэгжийн төлөх татварыг 90% хөнгөлөх хуулийн төслийг өргөн бариад байна.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ:90</p> <p>1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар болон гаалийн татварын бодлогоор жижиг, дунд үйлдвэрлэгч нарт дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх:</p> <ul style="list-style-type: none"> ❖ Улсын Их хурлаас Импортоор орж ирж байгаа жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлөх тухай хуулиудыг 2009-07-16-ны өдөр баталж 2013-12-31-ны өдрийг хүртэл мөрдөж, 2014-06-06-ны өдөр сунган 2016-12-31-ний өдөр хүртэл тус тус үйлчилсэн. ❖ Засгийн газрын 2009 оны 316 дугаар, 2011 оны 100 дугаар, 2012 оны 193 дугаар тогтоолуудаар 2009-2013 онуудад 37 нэрийн 1065 төрлийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, 2014 оны шинэчлэн баталсан 191 дүгээр тогтоолоор 2014-2016 онуудад 31 нэрийн 618 ширхэг тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн байна. ❖ Засгийн газрын 2014-06-14-ны 191 дүгээр тогтоолоор Гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас 2016-12-31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөгдөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг шинэчлэн баталж уг тогтоолын хавсралтад Засгийн газрын 2014-08-14-ний өдрийн 264-р тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан. ❖ Дэрхи хуулиудын хэрэгжилтийн хугацаанд 2009-2013 онуудад нийт 14074 иргэн, ААН, 2014-2016 онуудад нийт 6057 иргэн, ААН чөлөөлөлтөнд хамрагдсан байна. Хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл 92% нь аж ахуйн нэгж, 0,5% нь иргэн, 7,5% нь бусад /төрийн байгууллага, их дээд сургууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, ТББ, төлөөлөгчийн газар, хоршоо нөхөрлөл/ байна. ❖ 2014-2016 оны хугацаанд нийт 45 улсаас үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг импортлосон байна. Үүнээс 44,4 хувь нь БНХАУ-ын тоног төхөөрөмж байна. ❖ Гаалийн болон НӨАТ-ын чөлөөлөлтийн хуулиуд хэрэгжсэнээр арьс ширэн, ноос ноолууран, нэхмэл бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, нийт экспортод 2013 онд 16%, 2014 онд 15%, 2015 онд 20%-ийг тус тус эзэлж байна. ❖ 2014-2016 онуудад Гаалийн албан татвараас 13,2 тэрбум, Нэмэгдсэн өртгийн албан татвараас 27,7 тэрбум нийт 40,9 тэрбум төгрөг чөлөөлсөн байна. ❖ Жижиг, дунд үйлдвэрүүд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийснээр бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сайжирч зэрэгцээ үйлдвэрлэлийн бүтээмж 20-30%, борлуулалт 10-20%-иар нэмэгдсэн байна. ❖ Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар нарын боловсруулсан Жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийг 2017-02-02-ны өдөр Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэн батлуулав. <p style="text-align: right;">Үнэлгээ: 100</p> <p>1.5. Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх чиглэлийг салбар тус бүрээр тогтоох, бүс нутгийн онцлогт тулгуурласан тэргүүлэх салбарыг тодорхойлон тухайн салбарт дэмжлэг үзүүлэх эрх</p>
--	--	--

		<p>зүйн орчныг бүрдүүлэх;</p> <p>❖ Засгийн газрын 2009-06-10-ны өдөр баталсан 178 тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль болон аймгуудын онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн жижиг үйлдвэр, үйлдвэрлэл технологийн паркийг байгуулах, үйлдвэржүүлэлтийг бүс нутгийн хөгжлийн чиг баримжаа болгож, хөдөөд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх замаар орон нутгийн бие даасан байдлыг дэмжихээр тусгагдсан. Энэ тогтоолын хэрэгжүүлэх хүрээнд:</p> <p>❖ Эдийн засгийн хөгжлийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Хөдөлмөрийн сайд нарын хамтарсан 2013 оны 17, А/32, 38, А/30 дугаар тушаалын хүрээнд “Сум төсөл”-д ажлын хэсэг гарган ажиллаж 21 аймаг, 9 дүүрэгт байгуулах бизнес инкубатор төвүүдийн судалгааг хийсэн ба уг судалгаагаар сумын хүн амын тооноос хамааруулан (ө.х аймгийн төв, 5000-аас дээш хүн амтай сум, 3000-5000 хүн амтай сум, 3000 хүртэлх хүн амтай сум) ангилан, ангилал тус бүрд баригдах “Ахуйн үйлчилгээний төв”, “Бизнес инкубатор төв”, “Ахуйн үйлчилгээ, бизнесийг дэмжих төв”-ийн зураг төсвийг хийж гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллаж ирсэн байна. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, бизнес инкубаторыг аймаг бүрт байгуулахаар 2014-2018 оны хөрөнгө оруулалтын төсөлд саналаа тусган ажиллаж байна.</p> <p>❖ Бизнес инкубацийн үйлчилгээнд Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвөөс зарлагдсан тендерт 19 Бизнес инкубаторын төв шалгарч нийт 672 495 000 төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс 178 иргэн 176 265 501 төгрөгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, түрээсийн байрны хөнгөлөлт авсан. 141 иргэн, аж ахуй нэгж 155 552 604 төгрөгийн тоног төхөөрөмжийн түрээсийн хөнгөлөлтийг эдэлсэн байна. Борлуулалтын сүлжээ, түншлэлийн харилцаа холбоо тогтооход 153 иргэн, аж ахуй нэгжид 158 237 334 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Үзэсгэлэн яармаг оролцоход 145 иргэн, аж ахуй нэгжид 124 382 209 төгрөгийн дэмжлэг, 149 иргэн, аж ахуй нэгжид 58 057 352 төгрөгийн зөвлөх үйлчилгээний дэмжлэгийг тус тус үзүүлсэн.</p> <p>❖ 2015 онуудад Инкубацийн үйлчилгээнд санхүүжилтийн эх үүсвэр тусгагдаагүй тул тодорхой үйл ажиллагаанууд хийгдээгүй. 2016 оны инкубацийн үйлчилгээнд 100 гаруй иргэн, аж ахуйн нэгж бойжигдож, 3000 гаруй иргэн, аж ахуй нэгжид /үүнээс 2400 иргэн, 600 аж ахуй нэгж/ сургалтын үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>❖ 2015 оны төсвийн тухай хуулиар Аж үйлдвэрийн сайдын багцад батлагдсан Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/, Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/, Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/ арга хэмжээг Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн төвлөрүүлэн захирагчид эрх шилжүүлэн, үндсэн гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулж, гэрээнд заасан хугацаанд ажлыг дуусгах, гүйцэтгэлд хяналт тавих, барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авах ажлыг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосон. Дээрх хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийн ажлын гүйцэтгэл Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/-81%, Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/-100%, /, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/-100%, Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/-70%-тай байна. Эдгээр 4 төвийн санхүүжилтэнд Төсвийн хуулийн 14.4 дэх заалтын дагуу Аж үйлдвэрийн сайдын тушаалаар төсвийн төвлөрүүлэн захирагчид хөрөнгө оруулалтын арга хэмжээг</p>
--	--	--

		<p>хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэн, 1360,8 сая төгрөгийн гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжилтийг олгосон байна.</p> <p>❖ Хөдөө орон нутагт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр байгуулагдсан заримаас дурьдвал:</p> <ul style="list-style-type: none"> ➢ <u>Говь-Алтай аймагт</u> гутал, эсгий эдлэл, оёдол, барилгын материалын үйлдвэрлэл, гурил, мах, сүүний үйлдвэр зэрэг 7, ➢ <u>Увс аймагт</u> сүү боловсруулах үйлдвэр -1, Био бордоо тэжээлийн үйлдвэр-1, Жимс жимсгэний үйлдвэр-2, Фермерийн аж ахуй – 2, Давс боловсруулах үйлдвэр -1, Эсгийний үйлдвэр – 4, Оёдлын үйлдвэр – 3, Тавилгын үйлдвэр-4, Төмөр хийцийн үйлдвэр -1, Мах боловсруулах үйлдвэр-1, Сэндвич хавтангийн үйлдвэр -1, Бетон зуурмагийн үйлдвэр-1, Хөөсөнцөр, хөнгөн блокны үйлдвэр-1, Арьс шир боловсруулах үйлдвэр -1, Гутлын үйлдвэр – 8, Ахуйн үйлчилгээний төв – 6 суманд тус тус шинээр байгуулагдсан. ➢ <u>Баянхонгор аймагт</u> “Мах март” махны анхан шатны боловсруулалтын үйлдвэр, Сүү боловсруулах цех, үйлдвэр, Баянхонгор суманд модон эдлэлийн үйлдвэр, хаягдал сав баглаа боодлын үйлдвэр, өвлийн хүлэмж, 800 мкв талбай бүхий зуны хүлэмж-2, ➢ <u>Булган аймагт</u> 8 суманд хөргүүтэй зоорь, махны үйлдвэр-2, айраг савлах үйлдвэр, ➢ <u>Орхон аймагт</u> мах, засаг, ногоо, жимс боловсруулах үйлдвэр-5, сүүний -2, оёдлын-8, цаасан бүтээгдэхүүний -1, барилгын -5 үйлдвэр, ➢ <u>Ховд аймагт</u> давсны-1, барилгын материал-9, сүү цагаан идээний- 4 үйлдвэр, ➢ <u>Баянөлгий аймагт</u> чацаргана боловсруулж тос, жүүс хийдэг-1, өвлийн хүлэмж-1, эсгийний -3, 8 суманд ахуй үйлчилгээний төв, сум бүрт оёдлын үйлдвэр, махны үйлдвэр -1, ➢ <u>Дорнод аймагт</u> газар тариалангийн -15, МАА-2, оёдол -2, хэвлэл -3, зөгий – 3, ➢ <u>Дархан- Уул аймагт</u> Зам нөхөх бага оврын үйлдвэр, Үхэр үржүүлгийн ферм, хиймэл чулууны үйлдвэр шинээр ашиглалтанд тус тус орсон байна. <p style="text-align: right;">Үнэлгээ: 100</p> <p>1.6. Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;</p> <p>❖ Засгийн газрын 2014 оны 279 дүгээр тогтоолоор Ахуйн үйлчилгээний салбарыг дэмжих үндэсний хөтөлбөрийн батлагдсан. Хөтөлбөрийн хүрээнд:</p> <p>❖ Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ахуйн үйлчилгээ эрхлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2014 онд шинээр 138 суманд орон нутгийн өмчийн ашиглагдаагүй барилгыг ахуйн үйлчилгээний төвийн зориулалтаар ашиглаж эхэлсэн бөгөөд оёдол, гутал, фото зураг, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар, үсчин гоо сайханы чиглэлээр дээрх төвүүдэд 1080 шинэ ажлын байр бий болсон байна.</p> <p>❖ 2014 онд Ховд аймгийн Жаргалант суманд 761,7 төгрөгийн төсөвт өртөгтэй ахуйн үйлчилгээний төвийн барилгын төсөв батлагдсан. Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 97 тоот тушаалаар уг батлагдсан төсвөөс 217,7 төгрөгийг орон нутагт нь шууд мөнгө шилжүүлэх эрхийг олгосон байна.</p> <p>❖ “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр” 2014-2016 –ийн хүрээнд Хөдөлмөрийн сайдын 2014-10- 29-ний А/221 тоот тушаалаар баталсан нийт 12 тэрбум төгрөгний санхүүжилтээс нийт 6353 сая төгрөгийн санхүүжилт олгогдож улсын 21 аймгийн</p>
--	--	---

	<p>хэмжээнд 67 сумдад 67 “Ахуйн үйлчилгээний төв” шинээр бий болж 66 сумын төвийн 66 “Ахуйн үйлчилгээний төв”-ийн барилгыг засварлан шинэчилж үйл ажиллагаа эрхлэх тав тухтай орчинг бүрдүүлж, иргэдэд үйлчлэх нэгдсэн төвтэй болгосон байна.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Монгол улсын 21 аймгийн 330 сумдын хэмжээнд нийт 164 сумын ахуйн үйлчилгээний төвд хөрөнгө оруулалт хийж одоогоор нийт 221 төв үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. ❖ Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд нийт 3444 ажлын байр шинээр бий болж 431 ажлын байр сургалт семинарын явцад, 3013 ажлын байр ЖДҮХСан, Сум хөгжүүлэх сан, Зээлийн батлан даалтын сан болон бусад хэрэгжсэн төслийн хүрээнд бий болсон байна. Оноор нь авч үзвэл: <ul style="list-style-type: none"> ➢ 2014 онд 2218 ажлын байр, ➢ 2015 оны 684 ажлын байр, ➢ 2016 онд 542 ажлын байр тус тус бий болсон байна. ❖ Хөтөлбөрийн санхүүжилтэнд төсөвлөсөн 12 тэрбум төгрөгнөөс тодорхой бусад шалтгаануудаас үүдэн 5.647 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоогүйгээс 109 сумдад шинээр болон засварлан шинэчлэх 109 ахуйн үйлчилгээний төвийг барьж чадаагүй байна. ❖ Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр байгуулсан Ахуйн үйлчилгээний төвүүдийн ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн ур чадварыг сайжруулах зорилгоор 17 аймгийн 56 сумын 336 үйлчилгээ эрхлэгчдэд мэргэжил дээшлүүлэх сургалтыг Монголын үйлдвэрлэлийн хоршоодын төв холбоотой хамтран зохион байгуулан ажилласан. ❖ Хөтөлбөр хэрэгжих явцад Засгийн газрын бүтэц 2 удаа өөрчлөгдөж Ахуйн үйлчилгээний салбар 3 яамаар дамжсан нь хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж төлөвлөгдсөн санхүүжилт хийгдээгүйгээс хөтөлбөр бүрэн хэрэгжээгүй байна. <p style="text-align: right;">Үнэлгээ:100</p> <p>1.7. Үндэсний үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний дотоодын зах зээлийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> ❖ УИХ-ын 1999-03-27- ний өдрийн “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг батлах” тухай 27 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” 2015-07-09-ний 74 дүгээр тогтоол баталсан. Үүгээр Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999-06- 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 02, 04, 07, 08, 16, 19, 20, 21, 22, 25, 26, 35, 39, 40, 41, 42, 43, 44, 48, 49, 51, 56, 57, 61, 62, 63, 64, 68, 69, 70, 87, 94 дүгээр бүлэгт заасан хязгаарт багтаан холбогдох барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг тухайн салбарын бүтээгдэхүүний онцлогийг харгалзан тогтоох эрхийг Монгол Улсын Засгийн газарт олгож, “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999-06-03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 02, 04, 07, 08, 16, 19, 20, 21, 22, 25, 26, 35, 39, 40, 41, 42, 43, 44, 48, 49, 51, 56, 57, 61, 62, 63, 64, 68, 69, 70, 87, 94 дүгээр бүлгийн “5” гэснийг “20 хүртэл” гэж, 07 дугаар бүлгийн “15” гэснийг “20 хүртэл” гэж тус тус өөрчилсөн болно. ❖ Засгийн газрын 2015 оны 332 дугаар тогтоолоор Барааны уялдуулсан кодын системийн 02, 04, 16, 25, 87 дугаар бүлэгт 3 нэр төрлийн, 10 гаруй барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг нэмэгдүүлсэн. Үүнд: Мах, дайвар мах (адуу, үхэр, хонь, ямаа, тэмээ), зөгийн бал, нөөшилсөн бүтээгдэхүүн, цемент, троллейбус гэх мэт. ❖ Засгийн газрын 2015-08-17-ны 336 дугаар тогтоолоор
--	---

		<p>Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтыг баталж жагсаалтад заасан барааг нийлүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж жил бүрийн худалдан авахаар тусгасан. Үүний үр дүнд Хашаа, хаалга, тарилгын шингэн, тариа, нэг удаагийн тариур, ажлын хувцас зэрэг нийт 1,7 тэр бум төгрөгийн худалдан авалтыг дотоодын үйлдвэрүүдээс авсан мэдээтэй байна.</p> <p>❖ Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль 2016-02-05-ний өдөр батлагдаж Импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын болон бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг 2020-12-31-ний өдрийг хүртэл хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлөхөөр баталсан.</p> <p>❖ Засгийн газрын 2016-03-28-ний өдрийн 185-р тогтоолоор Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ”-ний 04, 07, 21, 39, 44, 49, 51, 56, 61, 63, 64, 68, 69, 94 дүгээр бүлэгт заасан зарим барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг шинэчлэн тогтоосон. Уг тогтоолоор 48 нэр төрлийн барааны импортын гаалийн албан татварыг нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд: Сүү цөцгий, Хүнсний ногоо, барилгын материал, модон тавилга гэх мэт.</p> <p>❖ Засгийн газрын 2016-04-04 –ний өдрийн Жагсаалт батлах тухай 197 дугаар тогтоолоор Гаалийн албан татвараас 2016-12-31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөх импортоор оруулж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг 1 дүгээр, Нэмэгдсэн өртгийн албан татвараас 2020-12-31-ний өдрийг хүртэлх хугацаанд чөлөөлөх, импортоор оруулж байгаа болон дотооддоо худалдан борлуулах шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын болон бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмж, усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсан.</p> <p>❖ Засгийн газрын 2016-08-17-ны 337 дугаар тогтоолоор Экспортод гаргасан нэмэгдсэн өртгийн албан татварын хувь, хэмжээ тэг хувь (“0”)-тай тэнцүү байх ноос, ноолуур, арьс ширээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний жагсаалтыг баталсан.</p> <p>❖ Засгийн газрын 2016-02-15-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор Импортын барааны гарал үүслийн дүрэмийг хавсралтаар шинэчлэн баталсан.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ: 100</p>
		<p style="text-align: center;">1-р зорилтын дундаж үнэлгээ: / хувиар/ 75,5</p> <p><u>Зорилт-2.Кластераар хөгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:</u> <u>Хүрэх үр дүн:</u> -Үйлдвэрлэлийн кластерыг дагаж бий болсон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн</p> <p>2.1. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн бүртгэл, статистикийн маягтыг боловсруулж нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийг иргэдэд ил тод болгох;</p> <p>❖ Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн бүртгэлийн статистикийн маягтыг боловсруулан 2013 оны 12 сард Үндэсний статистикийн хорооны “техникийн хороо”-ны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Үндэсний статистикийн хорооны дарга болон Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/04 тоот тушаалаар</p>

<p><i>тоо нэмэгдсэн байна.</i> <i>-Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хэвшүүлж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх хэрэглэгчийн тоо өссөн байна.</i></p>	<p>“Дэмжлэгт хамрагдсан жижиг, дунд үйлдвэрийн бүртгэл”-ийн маягтыг баталсан. Батлагдсан маягтыг 21 аймаг, нийслэл, 9 дүүрэгт хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Өнөөгийн байдлаар мэдээллийн нэгдсэн санд 5624 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг бүртгээд байна.</p> <p>❖ Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 53 тоот тушаалаар” Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн сангийн журам” баталсан. Уг тушаалын дагуу industry.mi.gov.mn-нд бүртгүүлэх ажлыг 2016 оны 4-5 сард хийж нийт бүртгүүлбэл зохих Жижиг дунд үйлдвэрийн 30 хувь нь бүртгүүлээд байна. Уг вэб сайтад суурилсан программ хийхэд 48 сая төгрөгийг зарцуулсан байна. Бүртгэлтэй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдээс 2014 онд 928 төсөлд 143,9 тэр бум төгрөг, 2015 онд 398 төсөлд 60,3 тэрбум, 2016 онд 103 төсөлд 74,4 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгож дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p>❖ Жижиг, дунд үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн сантай болох асуудлыг хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд нилээд байгууллагуудад санал болгож ажилласан. Үүний үр дүнд “Жижиг, дунд үйлдвэрийг санхүүжүүлэх замаар Монгол улсын эдийн засгийг төрөлжүүлэх” төслөөс мэдээллийн нэгдсэн санг бий болгохоор ажиллаж байна. Уг төсөл нь Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээл олгох, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг чадавхжуулах зорилготой 13.3 ам долларын санхүүжилттэй 2017-2019 онд хэрэгжих төсөл юм.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ: 90</p> <p>2.2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх хөшүүргийг бий болгох, бүртгэлтэй аж ахуйн нэгж, иргэнд төрөөс дэмжлэг, хөнгөлөлт авах тогтолцоог бүрдүүлэх;</p> <p>✓ Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 53 тоот тушаалаар” Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн сангийн журам” баталж боловсруулах үйлдвэрийн ангилалд багтах аж ахуйн нэгжийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох ажлыг эхлүүлсэн. 2016 оны жилийн эцсийн байдлаар мэдээллийн санд нийт боловсруулах үйлдвэрийн 30 хувь нь бүртгүүлсэн байна. industry.mi.gov.mn-нд бүртгүүлэх ажил хийгдэж байгаа бөгөөд энэхүү вэб сайтад суурилсан программ хийхэд 48 сая төгрөгийг зарцуулсан байна.</p> <p>✓ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 2011-2016 онд нийт 2580 Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг бүртгэгдсэн байна. Бүртгэлтэй ЖДҮ- эрхлэгчдээс 2014 онд 928 төсөлд 143,9 тэр бум төгрөг, 2015 онд 398 төсөлд 60,3 тэр бум, 2016 онд 103 төсөлд 74,4 тэр бум төгрөгийн зээлийг тус тус олгож дэмжлэг үзүүлсэн.</p> <p>✓ Засгийн газрын 2016-11-09-ний өдрийн “Түр журам батлах тухай” 138 дугаар тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаар 2016 онд олгох 35.0 /гучин тав/ хүртэл тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслүүдийг сонгон шалгаруулалтыг түр журмын дагуу яаралтай зохион байгуулахыг үүрэг болгосон. Энэ шийдвэрийн дагуу 2016-12-07-ны өдөр төсөл сонгон шалгаруулах ажил хийгдэж ирүүлсэн нийт 611 төслөөс 197 төсөл шалгарсан. “Төсөлд дэмжлэг үзүүлэх тухай” ХХААХҮСайдын 2016-12-09-ний А/62 тоот тушаалаар 2016-12-27-ны өдрийн байдлаар 14 иргэн, аж ахуй нэгж зээлийн гэрээ байгуулах шатанд, 44 иргэн, аж ахуй нэгж санхүүжилтийг шийдвэрлэхэд бэлэн, 83 иргэн, аж ахуй нэгж 39,6 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.</p>
---	---

<i>Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2010-2016 онд олгосон зээл / үйлдвэрлэлийн чиглэлээр/</i>						
Чигэлэл	Төслийн тоо	Зээл /сая.төг/	Үйл ажиллагаа		Ажлын байр	
			Өргөтгөсөн	шинээр	шинэ	хадгалсан
Хүнсний үйлдвэр	563	64572.70	95	11	3685	3481
Хөнгөн	1,122	73027.88	179	4	4659	4960
Газар тариалан	550	34033.72	87	29	2114	1807
Мал аж ахуй	668	40866.26	90	28	2618	1606
Барилгын үйлдвэрлэл	341	60462.75	79	12	3705	2241
Зоорь	83	21295.64	3	12	340	287
Био	29	6412.50	8	1	250	229
Худалдаа, үйлчилгээ	575	31260.30	57	23	3209	1994
Бусад	306	36811.18	70	37	1951	1765
Боловсруулах үйлдвэр	15	9280.50	12	3	92	132
Дахивар	2	580.00	2	-	54	35
Нийт	4254	378603.42	682	160	22677	18537

Мэдээллийн эх үүсвэр: Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан

Үнэлгээ: 90

2.3. Жижиг, дунд үйлдвэрийн салбарт кластер хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;

❖ 2015 оны төсвийн тухай хуулиар Аж үйлдвэрийн сайдын багцад батлагдсан Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/, Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/, Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/ арга хэмжээг Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн төвлөрүүлэн захирагчид эрх шилжүүлэн, үндсэн гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулж, гэрээнд заасан хугацаанд ажлыг дуусгах, гүйцэтгэлд хяналт тавих, барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авах ажлыг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосон. Дээрх хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийн ажлын гүйцэтгэл Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/-81%, Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/-100%, /, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/-100%, Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/-70%-тай байна. Дээрхи 4 төвийн арга хэмжээг Төсвийн хуулийн 14.4 дэх заалтын дагуу Аж үйлдвэрийн сайдын тушаалаар төсвийн төвлөрүүлэн захирагчид хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэн, 1360,8 сая төгрөгийн гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжилтийг олгосон байна.

❖ Хүн амын олноор суурьшсан УБ, Дархан –Уул аймаг, Эрдэнэт хотуудад үйл ажиллагаа явуулж буй оёмол, сүлжмэлийн жижиг дунд үйлдвэрүүд **кластераар хоршин** ажиллаж, Монгол хонины ноосны орц бүхий даавуугаар дүрэмт хувцас үйлдвэрлэхэд зориулж “Сурагчийн дүрэмт хувцас үйлдвэрлэх үндэсний үйлдвэрийг дэмжих тухай” ЗГ-ын 2013 оны 250 дугаар тогтоолоор 23 тэрбум төгрөгийн зээлийг 18 аж ахуйн нэгжид олгож үйлдвэрлэлийг явуулахад дэмжсэнээр нийт 2500 гаруй ажлын байр нэмэгдэж, дүрэмт хувцасны үйлдвэрлэлд оролцсон. Үүний үр дүнд Монгол хонины ноосон даавуугаар хийсэн дүрэмт хувцасаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдийн 90 орчим хувийг хангасан бөгөөд нийт сурагчид нэгдсэн загварын дүрэмт хувцас өмсөх боломж бүрдсэн. 2016-2017 оны хичээлийн жилд 551,9 мянган суралцагч суралцаж байна. Бага ангид 288.3, дунд ангид

	<p>167.3, ахлах ангид 96.2 мянган суралцагч суралцаж байна. Дүрэмт хувцасны үндсэн хувцасаар нийт суралцагчдын 73,4% хамрагдсан байна. Үүнээс: эрэгтэй суралцагчдын 68,6% нь хүрэм, өмдөөр хангагдсан бол эмэгтэй сурагчдын 78,2% нь сарафан цэнхэр цамцаар хангагдсан байна.</p> <p>❖ 2014 онд “Чацарганы кластерийн санаачилга” төсөл шалгаруулалт зохион байгуулж “Хархорин” ХК, “Эко-Эрдэнэ” ХХК, ШУТИС-ын Техник, технологи туршилтын төвийн түншлэлийг шалгаруулан 1.0 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг олгов.</p> <p>❖ 2015 онд “Чацарганы газар зүйн заалттай бүтээгдэхүүнээр бүртгэлжүүлэх, шинж чанар найрлагыг тодорхойлох, нэгдсэн өртгийн сүлжээ бий болгох” зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулж Монголын чацаргана тариалагч үйлдвэрлэгчдийн холбоотой гэрээ байгуулан гүйцэтгүүлэв</p> <p>✓ “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” УИХ-ын 2015-06-19-ны 62 дугаар тогтоолоор баталсан. Энэхүү бодлогын зорилго нь дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн салбарыг Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд оршино.</p> <p>✓ Түүнчлэн судалгаа хөгжлийн боловсруулалтын ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулж, үйлдвэрлэл, технологийн парк, үйлдвэрийн кластер, логистикийн сүлжээг хөгжүүлэх зэрэг эерэг үр дүн гарна. Уг бодлогыг хүрээнд “Монгол улсын аж үйлдвэрийн нэгдсэн төлөвлөлт, зураглал”-ыг ArcGIS программаар орон зайн боловсруулалт хийж хөгжлийн 5 бүс, 27 дэд бүстэйгээр боловсруулан, дэд бүс бүр дээр тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон Үүнд: Увс, Өвөрхангай аймагт чацарганы кластер, Сэлэнгэ аймагт зөгийн кластер хөгжүүлэхээр ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ: 90</p> <p>2.4. Жижиг, дунд үйлдвэрийн кластер байгуулах санаачилга, кластерт нэгдэх үйл ажиллагааг дэмжих, жижиг, дунд үйлдвэрийн кластерын талаар баримтлах стратегийг боловсруулах.</p> <p>❖ УИХ-ын 2015-06-19-ны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ыг баримт бичгийг батлуулж, жижиг, дунд үйлдвэрийн салбарт шинжлэх ухаан, төр, бизнесийн үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр дараах заалтууд тусгагдаад байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ төр, шинжлэх ухаан, боловсрол, бизнесийн байгууллагуудын хамтын үйл ажиллагаанд түшиглэсэн шинжлэх ухаан, технологи, инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх тогтолцоог дэмжих; ➢ үйлдвэрийн төлөвлөлт, судалгаа тооцоолол хийх, зураг төсөл боловсруулах, техник, технологийн патентуудыг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн тооцоот бие даасан хөгжлийн төв ажиллуулах; ➢ бизнес болон технологийн инкубаторийн тогтолцоогоор гарааны компаниудын үйл ажиллагааг дэмжих; ➢ чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг цогцоор барьж байгуулах; <p>❖ Хууль эрх зүйн хүрээнд кластерийг томъёолох, тодорхойлох шаардлагатай байгаа учир энэ кластерийн талаар “Жижиг, дунд үйлдвэр”-ийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын төсөлд тусгаад байна. Чацаргана болон Зөгийн балын бүтээгдэхүүнийг кластерийн тогтолцоогоор хөгжүүлэх талаар судалгаа хийж байгаа</p>
--	--

		<p>бөгөөд оролцогч талуудыг тодорхойлон ажиллаж байна.</p> <p>❖ Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон Увс аймаг дахь салбар зөвлөл хамтран” Чацаргана- Кластер-Увс” кластерийн баг байгуулан стратегийг тодорхойлон сургалтуудыг үе шаттайгаар хийж байна.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ: 70</i></p>
		<i>2-р зорилтын дундаж үнэлгээ: /хувиар/ 85,0</i>
	<p>Зорилт-3. Судалгаа боловсруулалт болон инновацийг хөгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:</p> <p>Хүрэх үр дүн: Дэмжлэгт хамрагдсан болон шинээр бий болсон ажлын байрны тооны өсөлт, салбар, бүс нутгаар тодорхой гарч, хөтөлбөрт хамрагдсан бизнес эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна.</p>	<p>3.1. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтын ажиллагаа өрнүүлэх;</p> <p>❖ Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Хүнсний инженер, биотехнологийн сургуулийн дэргэд улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв” байгуулагдан орчин үеийн өндөр үзүүлэлттэй лабораторийн тоног төхөөрөмжөөр, өндөр ур чадвартай боловсон хүчнээр хангагдан итгэмжлэлд хамрагдахаар ажиллаж байна.</p> <p>❖ Монгол улсын Боловсрол шинжлэх ухааны яам, БНХАУ-ын ШУТЯ хооронд хамтарсан лаборатори байгуулах тухай харилцан ойлголцлын санамж бичиг зурагдаж “Хятад-Монголын Молекул биологийн хэрэглээний хамтарсан лаборатори”-ийг Хөнгөн үйлдвэрийн шинжлэх ухаан технологийн үйлдвэрлэлийн “АРМОНО” нэгдлийн байранд 2015 оны 12 дугаар сард байгуулан лабораторийн үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна.</p> <p>❖ Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хооронд байгуулсан шинжлэх ухаан, технологийн талаар хамтран ажиллах гэрээний хүрээнд Солонгосын Шинжлэх ухаан, технологийн хүрээлэнгээс ирүүлсэн лабораторийн тусгай шинжилгээний багаж, тоног төхөөрөмжүүдээр МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль хоорондын дундын ашиглалтын лаборатори байгуулсан.</p> <p>❖ <u>Улсын төсвийн их, дээд сургуулийг дэмжих хөрөнгө оруулалтын талаар:</u></p> <p>❖ 2013 онд Монгол Улсын их сургуульд 3 лаборатори /Ерөнхий физикийн лаборатори, микро организмын биотехнологийн лаборатори, хурдас судлалын лаборатори/-ийг 368 саятөгрөгөөр,</p> <p>❖ Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн нэгдсэн лабораторид гүн хөлдөөгчийг 13 сая төгрөгөөр,</p> <p>❖ Соёл урлагийн их сургуульд киноны лабораторийг 200 сая төгрөгөөр,</p> <p>❖ ХААИС-ийн харъяа Дархан-Уул аймаг дахь хөдөө аж ахуйн сургуульд нарны цацрагийн автомат станцыг 26 орчим сая төгрөгөөр,</p> <p>❖ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Азийн хөгжлийн банкттай хамтран хэрэгжүүлж буй “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд Сургалтын орчин сайжруулах бүрэлдэхүүний хүрээнд МУИС, ХААИС, ШУТИС, МУБИС-д дундын ашиглалтын лаборатори нийлүүлэх үйл ажиллагаанд 1435467 ам.долларын тоног төхөөрөмж худалдан авч лабораторийн ашиглалт үйл ажиллагааг хангахаар ажиллаж байна</p> <p>❖ МУИС-ийн Бизнесийн Сургууль нь Монгол Улсад жижиг, дунд үйлдвэрлэлийн менежмент, бизнес эрхлэлтийн (энтрепренёршип) судалгаа хийх, судлаачдын сүлжээ үүсгэх, боловсрол олгох сургалт зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй судалгааны институт бөгөөд 2014 оноос хамтран Монгол Улсад хөгжүүлэх, гарааны бизнес, энтрепренёршип-н таатай орчин-экоосистемийг бий болгох, иргэд, аж ахуйн нэгжүүдийн энтрепренёрлэг сэтгэлгээ, урам зоригийг</p>

		<p>өдөөх, тухайн талбар дахь ололт, амжилтыг тэмдэглэхэд чиглэсэн чуулганыг 2014,2015,2016 онуудад тус бүр зохион байгуулсанбөгөөд үүний үр дүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Дэлхийн “энтрепренёршип”-н хөгжлийн чиг хандлагатай танилцах, байгууллагууд шинэ санаа, санаачилга, технологитой танилцах, үүнийг ажилдаа нэвтрүүлэх боломжийг олгосон. Чуулганы үеэр ЖДҮ-ийн чиглэлээр төрөөс баримтлах бодлого чиглэлийг танилцуулж, амжилттай сайн ажиллаж байгаа томоохон компаниуд өөрийн бизнесийн туршлага, түүхээс танилцуулсан. ➤ Шинээр үйлдвэр эрхэлж байгаа иргэд эдгээр туршлагыг нэвтрүүлж ажилласанаар борлуулалтын орлого нь 7-10 хувь нэмэгдсэн. ➤ Гарааны бизнес эрхлэгчид бизнес төлөвлөгөө хийж, өсөлтөнд хүргэхэд шаардлагатай мэдлэг, мэдээлэл авах, холбоо тогтоох, ирээдүйн бизнесийн хамтрагчаа олж авах боломж бүрдсэн байна. <p>❖ Эдгээр үйл ажиллагааг хамтран шинэлэг, үр дүнтэй, шилдэг шийдлээр өрх гэрүүдийн амьдралын чанарыг сайжруулж, өсөлтөд чиглэсэн бизнесийн чадавхийг бий болгох, байгаль орчинд ээлтэй нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой нийгэмд үйлчилдэг байгууллага болох Хөгжлийн Шийдэл ТББ болон хувь хүмүүс, баг бүлэг, нийгмийг бие даасан бизнес эрхлэлтэд (энтрепренёршип) уриалан дуудах, мэдлэг, боловсрол олгох, дэмжин туслах зорилготой манлайлагчид, бие даасан бизнес эрхлэгчдийн (энтрепренёр) дэлхий дахины сүлжээг Монгол Улсад төлөөлж буй Стартап Монголиа ТББ зохион байгуулж их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран 2014-2016 онд нийт 10 000 гаруй аж ахуйн нэгж, иргэнд сургалт, зөвөлгөө өгч ажилласан байна.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ: 90</i></p> <p>3.2. Жижиг, дунд үйлдвэрт инновацийг нэвтрүүлэхийг дэмжих, урамшуулах;</p> <p>❖ Жижиг, дунд үйлдвэрт инновацийг нэвтрүүлэхийг дэмжих, урамшуулах зорилгоор 2014 онд 535 үйлдвэр, 2015 онд 116 үйлдвэр, 2016 онд 57 үйлдвэр тус тус үйлдвэрээ өргөтгөн техник, технологи шинэчилэхэд зориулан хөнгөлөлттэй зээл олгосон.</p> <p>❖ Эрдэмтэдийн ШУТ болон Инновацийн төслийн хүрээнд сарлагийн хөөврийн бэлтгэлийн системд өөрчлөлт хийж, хөөврийг хяргаж биш самнаж авдаг шинэ стандартыг батлуулан бэлтгэгдсэн хөөврийн ноолуур агууламжийг 12-16 хувиар, уртыг 20 хувиар дээшлүүлж, түүхий эдийн үнэлэмжийг 10 дахин өсгөх боломжийг бүрдүүлсэн технологи, стандартууды ноос ноолуур боловсруулах тэргүүлэх үйлдвэрүүд болох “Эрдэнэт ноолуур-(Одоогийн шинэ нэр нь “Натураль Альфа” ХХК), “Мон-Форте” ХХК үйлдвэр, “Говь” ХК, “Санширо” ХХК, “Туяа” ХК “Монгол нэхмэл” ХХК, “Сор кашимер” “Баялаг-Өлзий” ХХК компаниуд үйлдвэрлэлд нэвтрүүлж ямааны ноолууран эдлэлтэй эн зэрэгцэхүйц шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Сарлагийн ноолууран нөмрөг - Патент №1485 ➤ Сарлагийн хөөврийг будалтанд бэлтгэн идэвхижүүлэх арга-ашигтай загварын гэрчилгээ №577 ➤ Сарлагийн ноолууран ширхэгтэд агуулагдах завсрын үсний өгөгдлийг нэмэгдүүлэх арга” Ашигтай загварын гэрчилгээ №2439 2015 онд авсан байна. <p>❖ “Монгол ямааны цэвэр ноолууран хагас нарийн ээрмэл үйлдвэрлэх технологи, 48/2-60/3 номерын ноолууран ээрмэл,</p>
--	--	---

		<p>сүлжмэл бүтээгдэхүүн” инновацийн бүтээл Монгол улсын 2015 оны “Шинжлэх ухааны шилдэг бүтээлийн тэргүүн байр” –н шагнал хүртсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Арьс ширний өндөр технологийн инкубатор төв Хурга, ишигний арьс боловсруулах Эко-технологи"-г мөн нэвтрүүлсэн байна. ❖ Хөдөө орон нутагт арьс шир, ноос боловсруулах өрхийн болон жижиг, дунд үйлдвэрийн 20 гаруй төрлийн 620-иод машин, тоног төхөөрөмжийг зохион бүтээж, туршин үйлдвэрлэж нийлүүлээд байна. ❖ УИХ-ын 2015- 06-19-ны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын дагуу "Үйлдвэрлэлийг дэмжих тухай" хууль 2015-07-09-ний өдөр батлагдсан. Уг хуульд дурьдсанаар дэвшилтэт технологийг нэвтрүүлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн 3 төрлийн дэмжлэг олгохоор тусгагдсан болно. ❖ Өндөр технологид суурилсан гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр мэдээллийн үйлчилгээ үзүүлэх вэбсайтыг бий болгох ажлын хүрээнд хэлтсийн вэбсайт болох www.ubindustry.mn сайтад домайн сайт үүсгэж нийслэлийн аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, нийслэлийн инновацийн хөгжлийн түвшний өнөөгийн байдал, нийслэлийн аж ахуйн нэгж, үйлдвэрийн газруудын инновацийн чадавхи, идэвхжлийн нэгдсэн үнэлгээ, инновацийн хөрөнгө оруулалтыг хийх төслийн шалгуур үзүүлэлтүүд, төсөл шалгаруулах журам, “Инновацийг хөгжүүлэх сан”-г байгуулах талаарх гадаад улс орнуудын туршлага зэрэг материалуудыг байршуулсан. <p style="text-align: right;">Үнэлгээ:100</p> <p>3.3. Оюуны өмчийн үр ашигтай менежментийг нэвтрүүлэх замаар жижиг, дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг өсгөх.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 267 дугаар тогтоолоор “Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, эзэмшүүлэх журам” батлагдсан. ❖ Монгол улсын Оюуны өмчийн газрын даргын 2016 оны А/27 дугаар тушаалаар Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг баталгаажуулах “Барааны тэмдэгийн гэрчилгээ”-г авсан. Үзэсгэлэн зохион байгуулж тодорхой номинацууд дээр энэ тэмдгийг хэрэглэх эрхийг Жижиг дунд үйлдвэр эрхлэгч нарт олгохоор болсон бөгөөд 2014-2016 онд нийт 3780 жижиг дунд үйлдвэр эрхлэгчид барааны тэмдэгийн гэрчилгээ авсан байна. ❖ Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн / тухайн үеийн нэрээр/ -ийн эрдэмтэд 10 гаруй жилийн суурь судалгаа, ШУТ-ийн төсөл болон инновацийн төслийн үр дүнд монгол хонины ноосоор барилгын дулаалгын материал үйлдвэрлэх инновацийг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. Одоогийн байдлаар “Ноосон дулаалга”-ын гарааны компани байгуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. ❖ Үслэг арьс боловсруулах туршилт үйлдвэрлэлийн цехийн технологийн бүх машин, тоног төхөөрөмжийг зохион бүтээж, “Ноосон дулаалга” Гарааны компани болон Арьс шир боловсруулах өндөр технологийн инкубаторын туршилт үйлдвэрлэлийн цехүүдийн машин, тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулан, тохируулж, зарим тоног төхөөрөмжийг үйлдвэрлэн, байр болон дэд бүтцийн хамт ажилд бэлэн болгосон. ❖ Газар тариалангийн салбарт эрдэмтэн, судлаачдын судалгаа,
--	--	---

		<p>шинжилгээний ажлын үр дүнд 2012-2015 онд үр тарианы 96 сорт; төмсний 14 сорт, хүнсний ногооны 39 сорт, жимс жимсгэний 16 сорт бий болсон бөгөөд үр тарианы сортын 30 хувь, төмсний сорт 100 хувь, хүнсний ногооны сортын 60 хувь, жимс, жимсгэний сортын 70 хувь нь Монголд тариалагдаж байна. Мөн төрөл бүрийн таримлуудыг тарималжуулж ургуулах 120 технологийн зөвлөмж боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна.</p> <p>❖ Мал эмнэлгийн салбарын эрдэмтэн судлаачдын 4 нээлт Дэлхийн шинжлэх ухаанд өвд бүртгэгдэж, малын эмчилгээний 64 вакцин, оношлуур, 72 эм, био бэлдмэл бий болсон байна. Үр дүнг нь шууд үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой 200 гаруй технологи, бүтээгдэхүүн бэлэн болоод байна.</p> <p>❖ Мал аж ахуйн салбарт адууны 1 үүлдэр 3 омог, тэмээний 3 үүлдэр, үхрийн 3 үүлдэр, хонины 22 үүлдэр, ямааны 4 үүлдэр, 5 омог бий болж баталгаажсан байна.</p> <p>❖ Салбарын эрдэмтэн, судлаачдын оюуны бүтээлийг дэмжих зорилгоор “Судалгааны ажилд грант олгох журам”-ыг ХХАА-н сайдын 2015 оны А/80 дугаар тушаалаар батлуулав. Журмын дагуу Грант горилж ирсэн бүтээлүүдийн шалгаруулалтыг зохион байгуулж “Судалгааны ажилд грант олгох тухай” ХХАА-н сайдын 2015 оны А/17, 2016 оны А/58 дугаар тушаалаар 4 бүтээлийн багт 40 сая төгрөг олгосон.</p> <p>❖ Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухаан, технологи, инноваци” Үндэсний чуулганыг 2016.03.23-ны өдөр зохион байгуулж, салбарын хэмжээнд сүүлийн 10 жилд хэрэгжсэн шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнд бий болсон 510 бүтээгдэхүүнийг багтаасан “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шинжлэх ухаан, технологи, инновацийн бүтээгдэхүүний эмхэтгэл”-ийг хэвлэн гаргав</p> <p>❖ Жижиг, дунд үйлдвэрийг өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор 2014 онд “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”, 2016 оныг ”Дотоодын үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих жил”-ээр зарлан жижиг дунд үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх тодорхой бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Тухайлбал: Эргэлтийн хөрөнгө, ажлын байр өргөтгөх болон шинээр барих, тоног төхөөрөмж авахад зориулан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2014-2016 онд 1429 Жижиг, дунд үйлдвэрт 283,5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 7-9 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай олгосон.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ:90</p> <p>3.4. Жижиг, дунд үйлдвэрийн нийгэм, эдийн засагт гүйцэтгээж байгаа үүргийг тооцох аргачлалыг боловсруулах.</p> <p>❖ Үндэсний статистикийн газраас жижиг, дунд үйлдвэр эрхлэгчтэй холбоотой тоон мэдээллийг дараах аргачлал, нөхцөлөөр шүүлт хийн боловсруулж байна.Эдийн засгийн салбараас зөвхөн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид хамаарах салбарыг сонгон:</p> <p>-Бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо -Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо -Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг эдийн засгийн салбар бүрээр ажиллагсадын тоог гаргадаг.</p> <p>❖ “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” 5.1 дэх заалтын дагуу ЖДҮ эрхлэгчдийн тодорхойлолтын дагуу Гааль, татварын ерөнхий газраас жилийн 1,5 тэрбум төгрөг хүртэл борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн тоог авч Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллийн сантай тулгаж үзэхэд 50,2% нь харъяа нийгмийн даатгалын хэлтэстээ бүртгүүлээгүй байсан. Бүртгэлийг</p>
--	--	---

		<p>идэвхжүүлэх талаар 2017-2020 онд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газар, Үндэсний Статистик, Гааль татварын ерөнхий газар, Татварын ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичигт ЖДҮ-ийн нийгэм, эдийн засагт гүйцэтгэж байгаа үүргийг тооцох аргачлалыг боловсруулах талаар заалтууд оруулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ:30</p>
		3-р зорилтын дундаж үнэлгээ: /хувиар/ 77,5
	<p>Зорилт 4.Жижиг дунд үйлдвэрийг чадавхижуулах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:</p> <p>Хүрэх үр дүн: -Бизнес-инкубацийн үйлчилгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо өссөн байна.</p> <p>-Шинэ санаачилга, техник технологи, инновацийг дэмжсэнээр жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар сайжирч, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бүрдүүлсэн байна.</p>	<p>4.1. Өндөр технологи, мэдлэг, нэмүү өртөг шингэсэн жижиг, дунд үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхижуулах;</p> <p>❖ Аж үйлдвэрийн яамнаас 2015-02-04, 2015-10-09, 2016-03-25-ны өдрүүдэд 21 аймаг, 9 дүүргийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан 51 мэргэжилтэнд чадавхижуулах сургалт зохион байгуулж, холбогдох яам, мэргэжлийн байгууллагуудыг урьж мэдээлэл хийлгэж ажилласан. Сургалтаар Төрөөс аж үйлдвэр, хөдөлмөрийн салбаруудад баримтлах бодлогын баримт бичгүүд, арьс шир, ноос ноолуур, үйлдвэрлэлийн салбарын мэдээллүүдээс гадна аутсорсинг, оюуны өмч, стандартын талаар сургалтууд хийгдсэн. Сургалтанд оролцсон мэргэжилтнүүд орон нутгийн ЖДҮ эрхлэгчдэд давхар сургалт хийж давхардсан тоогоор нийслэлд 100, аймгуудад 84 үйлдвэрлэгчид сургалтанд хамрагдсан байна.</p> <p>❖ Мөн 2015-03-20-ны өдөр Жижиг, дунд үйлдвэрүүдэд тоног төхөөрөмжийг иж бүрэн ашиглах нь” сургалтыг Монголын Бүтээмжийн байгууллагатай хамтран зохион байгуулсан. Сургалтанд жижиг, дунд үйлдвэр эрхлэгч 50 байгууллагын төлөөлөл оролцсон байна.</p> <p>❖ Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” төслийн хүрээнд Аж үйлдвэрийн яамны ЖДҮ-ийн салбарын албан хаагчдыг чадавхижуулах “Экспортын зөвлөх үйлчилгээ”, “Тендер боловсруулалт” сэдэвт сургалтуудыг 2015-02-16-17, 2015-03-10-11 өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтанд Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Жижиг, дунд үйлдвэрийн хөгжүүлэх сангийн нийт 14 мэргэжилтэн хамрагдсан болно.</p> <p>❖ Японы ЖАЙКА байгууллагын дэмжлэгээр 2014 онд 1 хүн, 2015 онд 17 хүн, 2016 онд 11 хүн, 2017 онд 2 хүн тус тус 10-45 хоногийн хугацаанд Жижиг, дунд үйлдвэрэрхлэх чиглэлээр сургалтанд хамрагдсан байна.</p> <p>❖ 2016 онд Дэлхийн банкны “Хөдөөгийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд “Жижиг, дунд үйлдвэрийн хөрөнгө оруулалтын төсөл бичих” сургалтад ХХААХҮЯ-наас 9 хүн сурч гэрчилгээ авсан.</p> <p>❖ Стартап Монголиа ТББ-аас бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд давхардсан тоогоор 2014-2016 онд 10 000 хүнд сургалт, зөвлөгөө өгч ажилласан байна.</p> <p>❖ Монголын Үндэсний бизнес инкубаторын нэгдсэн холбооноос 2014-2016 онд нийт 7000 бичил болон, жижиг аж ахуй нэгж, иргэнд технологи, санхүү, бизнесийн талаар сургалтууд зохион байгуулав.</p> <p>❖ Монголын Хоршооллын нэгдсэн холбооны сургалтын төвөөс 2014-2016 онд 5000 гаруй хоршооны гишүүдэд сургалт хийсэн байна.</p> <p>❖ Арьс ширний үйлдвэрийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх зорилгоор Монгол Солонгосын коллежид шинээр анги нээж ажиллуулах хүсэлтийг хүргүүлсэн.</p> <p>❖ Салбарын эрдэмтдийн хамтран боловсруулсан сүүний</p>

		<p>салбарын мэргэжилтэн бэлтгэхэд зориулсан “Монгол орны сүү үйлдвэрлэл” номыг дахин сайжруулан боловсруулж, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төсөл”-тэй хамтран хэвлүүлсэн. Мөн тус төсөлтэй хамтран Монголын Сүүний Салбарыг Хөгжүүлэх Үндэсний Зөвлөл “Сүүний үйлдвэрлэл дэх хөдөө аж ахуйн, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал” сэдэвт сургалтыг Архангай аймгийн Эрдэнэбулган суманд 2016-06-10-11-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 40 хүн оролцсон.</p> <p>❖ Баянхонгор аймгийн төвд Дэлхийн зөн ОУБ, Сүүний салбарыг хөгжүүлэх үндэсний зөвлөл хамтран "Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлсүүний нэмүү өртгийн сүлжээ"сэдэвт 3 хоногийн сургалтыг 2016-05-26-28-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 9 сумын47 сүүний үйлдвэрлэл эрхлэгчид оролцсон байна.</p> <p>❖ МонголУлсын Хүнс, хөдөө ажахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Туркийнхамтынажиллагаа, зохицуулахагентлаг (ТИКА), ТуркийнСтандартынИнститут (ТСИ)-ийнхамтынажиллагааны хүрээнд ТИКА байгууллагаас санхүүжүүлэн “Мал нядалгааны халал стандартыг нэвтрүүлэх” сэдэвт 2 үе шаттай сургалтыг 2016 оны 4, 12 дугаар саруудад зохион байгуулж нийт 21 үйлдвэрийн 35 технологич, 30 мал нядлагчдыг хамруулав. Энэхүү сургалтыг Монголд улсад мал нядалгааны халал стандартыг нэвтрүүлж, хонины махны хэрэглээ бүхий экспортын чухал зах зээл болохАрабынболонИсламынорнуудад мах болон махан бүтээгдэхүүнийг экспортлох зорилгоор зохион байгуулав.</p> <p>❖ Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр байгуулсан Ахуйн үйлчилгээний төвүүдийн ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн ур чадварыг сайжруулах зорилгоор 17 аймгийн 56 сумын 336 үйлчилгээ эрхлэгчдэд мэргэжил дээшлүүлэх сургалтыг Монголын үйлдвэрлэлийн хоршоодын төв холбоотой хамтран зохион байгуулав.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ:100</p> <p>4.2. Жижиг, дунд үйлдвэрийн технологийн шинэчлэлийг технологи дамжуулах үйл ажиллагаагаар дэмжих;</p> <p>❖ “Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл” батлах тухай ЗГ-ын 2009 оны 178 тогтоолын дагууБаянхонгор, Говьалтай аймагт угаасан ноос, Архангай , Хөвсгөл, Говьсүмбэр, Өвөрхангай, Баянөлгий, Төв, Хэнтий аймагт ноос угаах, самнах үйлдвэр, Дархан- Уул аймагт нарийн, бүдүүн ээрмэлийн үйлдвэр, Архангай аймагт барилгын дулаалгын материал, Орхон аймагт хивс, эсгий бүтээгдэхүүний үйлдвэр, Төв аймагт нарийн бүдүүн ээрэх үйлдвэр тус тус шинэ технологи нэвтрүүлэн, шинээр байгуулагдсан.</p> <p>❖ Эдийн засгийн хөгжлийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Хөдөлмөрийн сайд нарын хамтарсан 2013 оны 17, А/32, 38, А/30 дугаар тушаалын хүрээнд “Сум төсөл”-д ажлын хэсэг гарган ажиллаж 21 аймаг , 9 дүүрэгт байгуулах бизнес инкубатор төвүүдийн судалгааг хийсэн ба уг судалгаагаар сумын хүн амын тооноос хамааруулан (ө.х аймгийн төв, 5000-аас дээш хүн амтай сум, 3000-5000 хүн амтай сум, 3000 хүртэлх хүн амтай сум) ангилан, ангилал тус бүрд баригдах “Ахуйн үйлчилгээний төв”, “Бизнес инкубатор төв”, “Ахуйн үйлчилгээ, бизнесийг дэмжих төв”-ийн зураг төсвийг хийж гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, бизнес инкубаторыг аймаг бүрт байгуулахаар 2014-2018 оны хөрөнгө оруулалтын төсөлд саналаа тусган ажиллав.</p> <p>❖ 2015 оны төсвийн тухай хуулиар Аж үйлдвэрийн сайдын багцад батлагдсан Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв</p>
--	--	---

		<p>/Баянхонгор, Баянхонгор сум/, Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/, Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/ арга хэмжээг Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн төвлөрүүлэн захирагчид эрх шилжүүлэн, үндсэн гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулж, гэрээнд заасан хугацаанд ажлыг дуусгах, гүйцэтгэлд хяналт тавих, барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авах ажлыг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосон. Дээрх хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийн ажлын гүйцэтгэл Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/-81%, Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/-100%, /, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/-100%, Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/-70%-тай байна. Дээрхи 4 төвийн арга хэмжээг Төсвийн хуулийн 14.4 дэх заалтын дагуу Аж үйлдвэрийн сайдын тушаалаар төсвийн төвлөрүүлэн захирагчид хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэн, 1360,8 сая төгрөгийн гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжилтийг олгосон байна.</p> <p>❖ Бизнес инкубацийн үйлчилгээн/БИТ/-д Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвөөс зарлагдсан тендерт 19 БИТ шалгарч нийт 672495000 төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс 178 иргэн 176265501 төгрөгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, түрээсийн байрны хөнгөлөлт авсан. 141 иргэн, аж ахуй нэгж/ААН/-д 155552604 төгрөгийн тоног төхөөрөмжийн түрээсийн хөнгөлөлтийг эдэлсэн байна. Борлуулалтын сүлжээ, түншлэлийн харилцаа холбоо тогтооход 153 иргэн, ААН-д 158237334 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Үзэсгэлэн яармаг оролцоход 145 иргэн, ААН-д 124382209 төгрөгийн дэмжлэг, 149 иргэн, ААН-д 58057352 төгрөгийн зөвлөх үйлчилгээний дэмжлэгийг тус тус үзүүлсэн</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ: 90</i></p> <p>4.3. Хүүхэд, залууст бизнесийн соёл эзэмшүүлэн бэлтгэх үйл ажиллагааг дэмжих;</p> <p>❖ Аж үйлдвэрийн яамМонгол Улсад гарааны бизнес, энтрепренёршипын таатай орчин-экоосистемийг бий болгох, иргэд, аж ахуйн нэгжүүдийн энтрепренёрлэг сэтгэлгээ, урам зоригийг өдөөх, тухайн талбар дахь ололт, амжилтыг тэмдэглэх зорилгоор “Дэлхийд өрсөлдөх гарааны бизнесийн хөгжил өөд” чуулганыг 2015 онд 2 дахь удаагаа зохион байгуулсан.</p> <p>❖ Стартап Монголиа ТТБ залуучуудад зориулан 2015 оноос хойш Startup weekend, Design thinking, Startup Grind , Drink Entrepreneurs, Startup Next зэрэг нийт 24 төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийт арван мянга гаруй залуучууд Стартап Монголиа ТТБ-тай хамтран ажилласан бөгөөд нийт 200 гаруй стартап компаниуд бизнесийн зөвлөх үйлчилгээ авснаас 100 гаруй нь үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа 100 үйлдвэрээс20 компани нь шинээр хөрөнгө оруулалт хийж амжилттай ажиллаж байна.</p> <p>❖ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банк хамтран 2015-2019 онд хэрэгжих “Хөдөлмөр эрхлэх ур чадвар дээшлүүлэх” төсөл хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд 2016 оны 8 дугаар сард Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулсан.</p> <p>❖ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014-06-27-ний өдрийн А/285 дугаар тушаалаар Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн</p>
--	--	--

		<p>жагсаалтыг баталсан.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцах сонирхлыг бий болгох үүднээс суралцагчдад олгох тэтгэлгийн хэмжээг 70 мянган төгрөг болгон нэмэгдүүлж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг олон нийтэд нээлттэй хүргэх тогтолцоог бий болгон, сургалтын хөтөлбөр, арга зүйг боловсронгуй болгосон ба 25 мянган хүний чадавхийг дээшлүүлсэн. ❖ 2013-2016 онд давхардсан тоогоор улсын төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрөөс 67.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар мэргэжлийн боловсрол, сургалтын 61 байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, сургалтын орчин нөхцлийг сайжруулсан. ❖ Төрийн бус өмчийн мэргэжлийн сургалтын 32 байгууллагын 40 мянган суралцагчийн тэтгэлэгт 13.6 тэрбум, хувьсах зардалд 15 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлж, арга зүй, боловсон хүчний чадавхийг нь дэмжсэнээр сургалтын байгууллагуудын шударга өрсөлдөх боломжийг дээшлүүлэн, сургалтын чанар, үр дүнд анхаарч ажилласан. ❖ Мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлэх, ажил олгогчтой холбож, үр дүнг сайжруулах зорилгоор хөтөлбөрийн хугацаанд “Армони” корпораци, “Хасу мегавайт” ХХК зэрэг томоохон 14 аж ахуйн нэгж, байгууллагад сургалтын зөвшөөрөл олгон, арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. ❖ Дээрхи арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2013-2015 онуудад мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудад 61.3 мянган суралцагчийг 193 мэргэжлээр элсүүлсний 62.8 хувь нь хөдөлмөрийн зах зээлд хамгийн өндөр эрэлттэй аж үйлдвэр, барилга, уул уурхайн чиглэлээр суралцаж, 60.7 мянган суралцагч төгссөний 59 хувь нь ажлын байртай болсон. ❖ Хувийн хэвшил, ажил олгогчийн эрэлт, технологийн тэргүүлэх чиглэл, өндөр технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн захиалгыг тэргүүн ээлжинд харгалзан үзэж, төрийн сангийн хөрөнгөөр боловсон хүчин бэлтгэх ажил хийгдэж байна. <p style="text-align: right;">Үнэлгээ:100</p> <p>4.4 Жижиг, дунд үйлдвэрт ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоог сайжруулан мэргэжлийн ажилчид бэлтгэх</p> <ul style="list-style-type: none"> ❖ Төрийн бус өмчийн мэргэжлийн сургалтын 32 байгууллагын 40 мянган суралцагчийн тэтгэлэгт 13.6 тэрбум, хувьсах зардалд 15 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлж, арга зүй, боловсон хүчний чадавхийг нь дэмжсэнээр сургалтын байгууллагуудын шударга өрсөлдөх боломжийг дээшлүүлэн, сургалтын чанар, үр дүнд анхаарч ажилласан. ❖ Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцах сонирхлыг бий болгох үүднээс суралцагчдад олгох тэтгэлгийн хэмжээг 70 мянган төгрөг болгон нэмэгдүүлж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг олон нийтэд нээлттэй хүргэх тогтолцоог бий болгон, сургалтын хөтөлбөр, арга зүйг боловсронгуй болгосон ба 25 мянган хүний чадавхийг дээшлүүлсэн. ❖ 2013-2016 онд давхардсан тоогоор улсын төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрөөс 67.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар мэргэжлийн боловсрол, сургалтын 61 байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, сургалтын орчин нөхцлийг сайжруулсан. ❖ Мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлэх, ажил олгогчтой холбож, үр дүнг сайжруулах зорилгоор хөтөлбөрийн хугацаанд “Армони” корпораци, “Хасу мегавайт” ХХК зэрэг томоохон 14 аж ахуйн нэгж, байгууллагад сургалтын зөвшөөрөл
--	--	--

		<p>олгон, арга зүй, санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Дээрхи арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2013-2015 онуудад мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудад 61.3 мянган суралцагчийг 193 мэргэжлээр элсүүлсний 62.8 хувь нь хөдөлмөрийн зах зээлд хамгийн өндөр эрэлттэй аж үйлдвэр, барилга, уул уурхайн чиглэлээр суралцаж, 60.7 мянган суралцагч төгссөний 59 хувь нь ажлын байртай болсон. ❖ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014-09-12-ний өдрийн А/370 дугаар тушаалаар “Магистр, докторын мэргэжлийн чиглэл, индекс, журам батлах, дүрэм”-д өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан. ❖ 2016 онд “Орлоготой оюутан” хөтөлбөрийг оюутны цагийн ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх чиглэл баримтлан боловсруулж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн батлуулсан. ❖ Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд “Дээд боловсролын сургалтын байгууллага ба үйлдвэрлэлийн түншлэлийг хөгжүүлэх төсөлд тэтгэлэг олгох журам” батлагдан хэрэгжиж байна. Нийт 13 төсөлд, 485 000 000 төгрөгийн санхүүжилт олгохоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны А/26 дугаар тушаалаар батлагдан, гэрээ байгуулан ажиллаж байна. ❖ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014-06-27-ний өдрийн А/285 дугаар тушаалаар Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалтыг баталсан. ❖ Хувийн хэвшил, ажил олгогчийн эрэлт, технологийн тэргүүлэх чиглэл, өндөр технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн захиалгыг тэргүүн ээлжинд харгалзан үзэж, төрийн сангийн хөрөнгөөр боловсон хүчин бэлтгэх юм. ❖ “Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр”-т хамрагсад тэтгэлэгтэй суралцах орчин бүрдэж, сургалтанд хамрагдаж, ажилд орох хүсэлтэй хотын 5217, орон нутгийн 5100 иргэн 2015-01-06-29-нийг дуустал Хөдөлмөрийн төв бирж, харьяа дүүргийхээ Хөдөлмөрийн хэлтсүүд дээр бүртгүүлсэн бол ажил олгогчдоос хотын 4126 орон нутгийн 3800 ажлын байрны захиалга ирсэн байна. Бүх суралцагчид ажил олгогчидтой ярилцлага зохион байгуулсны үндсэн дээр сонгон шалгаруулгад тэнцэж, Улаанбаатар хотод 2088, орон нутагт 3600 ажил хайгчтай гэрээ байгуулсан байна. Хөтөлбөрт хамрагдагчид Улаанбаатар хотод 26, хөдөө орон нутагт 31 мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад 53 мэргэжлээр суралцаж, эхний 2 сарыг танхимд онолын мэдлэг заалгаж, үлдсэн 3 сарыг ажил олгогч ажлын байран дээр үйлдвэрлэлийн дадлага хийсэн. Онолын мэдлэг, үйлдвэрлэлийн дадлага хосолсон сургалтын хэлбэрээр явагдаж буй тус сургалт мэргэжлийн агуулга, хөтөлбөрөөс шалтгаалан 5 сар хүртэлх хугацаатай хийгдсэн. <p style="text-align: right;"><i>Үнэлгээ:100</i></p> <p><u>4.5. Мэргэжлийн сургалт, үйлдвэрийн төвтэй хамтран ажиллах;</u></p> <ul style="list-style-type: none"> ❖ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх үүднээс 2013-2014 онуудад 340 аж ахуйн нэгжээр мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, дээшлүүлэх богино хугацааны сургалтыг, аж ахуй эрхлэлтийн 41 төв, 19 бизнес инкубатор төвөөр дамжуулан бизнесийн сургалт, зөвлөгөө, мэдээллийг гэрээгээр гүйцэтгүүлж, төрөөс санхүүжүүлэх замаар 29.4 мянган хүнийг хамруулснаар 61 хувь нь ажлын байртай болсон.
--	--	---

		<ul style="list-style-type: none"> ❖ Хөдөлмөрийн яам, Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооны хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлж, нийгэмд гүйцэтгэх үүргийг нь сурталчлах зорилгоор гишүүн хоршоологчдод харилцан мэдээлэл, туршлага солилцох боломж бүрдүүлэх, тэдэнд сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх хүрээнд “Хоршоологчдын харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг бэхжүүлэх, бүсчилсэн үзүүлэх сургууль”-ийг Дорнод, Говь-Алтай, Увс, Өвөрхангайд хоршоологчид хоршоог дэмжигч байгууллагыг оролцоотойгоор зохион байгууллаа. ❖ Олон улсын Хоршооллын Альянсын Ази Номхон далайн бүсийн холбооноос ирүүлсэн хүсэлтийн хүрээнд “Хоршооллын бизнест эмэгтэйчүүдийн үүргийг нэмэгдүүлэх нь” бүсийн уулзалтыг улс орнуудын хооронд туршлага судлах зорилгоор 1 өдрийн семинар, 2 өдрийн хоршоодын үйл ажиллагаатай танилцах нийт 3 өдрийн арга хэмжээг зохион байгуулав. Арга хэмжээг Олон улсын Альянсын гишүүн хоршооллын байгууллага, хоршоодын удирдлагын 10-12 хүн, Монгол талын төлөөлөл бүхий нийт 50 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулсан байна. ❖ Монголын худалдаа эд хэрэглэгчдийн хоршоодын Төв холбоо сүүлийн жилүүдэд худалдаа, үйлчилгээний ажлыг боловсронгуй болгох, худалдаа үйлчилгээг мэргэжлийн хүнээр эрхлүүлэх зайлшгүй шаардлагыг нийтэд ойлгуулан, мэргэжлийн худалдагч бэлтгэх сургалтыг Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Дэлхийн зөн, аймгуудын худалдаа эд хэрэглэгчдийн холбоодтойгоо хамтран зохион байгуулж ажиллаж байна. Энэ хугацаанд төв орон нутаг дахь өөрийн гишүүн байгууллагуудтай хамтран худалдагчийн сургалт зохион байгуулж, нийт 26 сургалтаар 600-аад мэргэжлийн худалдагч бэлтгэсэн байна. ❖ Хоршооны болон аж ахуйн нэгж, хувиараа бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах нийт 7 сургалтанд 675 хүн хамруулсан байна. ❖ Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоогоор доорх ажлыг хийж гүйцэтгүүллээ. <u>Үүнд:</u> <ul style="list-style-type: none"> ➢ ”Хоршооллын салбарын түншлэл” сүлжээ уулзалтыг 2014-09-10 өдөр хоршоод, хоршоодыг дэмжигч гадаадын төсөл хөтөлбөр уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтаар Монголын хоршооллын хөгжилд тулгамдаж буй чухал асуудлуудын талаар хэлэлцэх боломжийг хоршооллын салбарт үйл ажиллагаа явуулагч харилцан адилгүй үүрэг бүхий олон гишүүдэд Хоршооллын салбарт түншлэл, хамтын ажиллагааны шинэ хэлбэр СҮЛЖЭЭ үүсгэн байгуулах талаар тохиролцлоо. ➢ Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/151 тоот тушаалаар 2014-09-16-20 өдрүүдэд болсон Ази, Номхон далайн бүсийн хоршоологчдын 11 дүгээр чуулганд Монгол улсыг төлөөлж хоршоодын холбооны төлөөлийг оролцуулах ажлыг зохион байгууллаа. Чуулганд хөтөлбөрийн дагуу оролцож нээлтийн үйл ажиллагаанд “Монгол улсад хоршооллын хөгжил, өнөөгийн байдал, цаашид хоршооллын талаар авах арга хэмжээ” талаар илтгэл тавьж оролцогчдын сонирхсон асуултанд хариулт өгч оролцсон байна. ❖ Шинжлэх ухааныг түгээн дэлгэрүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, эрдэмтдийн оюуны бүтээлийг сурталчлах ажлын төлөвлөгөөг жил бүр БСШУ-ны Сайдын тушаалаар батлуулан хэрэгжүүлж ирсэн. Энэ ажлын хүрээнд:
--	--	--

		<p>➤ Шинжлэх ухааны академитай хамтран “Эрдэмтдийн үг” цуврал лекц жил бүр 10-ийг зохион байгуулсан. Лекцэд тухайн сэдвийн дагуу холбогдох эрдэмтэн судлаачид, багш, оюутнууд, хэвлэл мэдээллийн ажилтнууд, олон нийтийн төлөөлөл хамрагдах бөгөөд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газраас санаачлан лекцийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор лекц тус бүрийн бичлэгийг хийж архивлан, онлайн хэлбэрээр буюу www.scimedia.mas.ac.mn-д байршуулж олон нийтэд түгээн ажиллаж байна. Одоогийн байдлаар онлайнаар байршуулсан “Эрдэмтдийн үг” лекцийн бичлэгийг нийт 750 зочин үзэж, 2500 удаа хандсан байна. Мөн цуврал 10 лекцийг МҮОНТ, Ийгл телевиз, Эх орон, Монцамэ агентлаг, www.gogo.mn, www.mas.ac.mn, www.unuudur.mn, www.news.mn, www.dorgio.mn, www.breakingnews.mn зэрэг мэдээллийн сайтуудаар сурталчилж, мэдээ мэдээлэл бэлтгэн олон нийтэд хүргэж байна. Түүнчлэн өдөр тутмын “Өдрийн сонин”, “Үндэсний шуудан, ШУА-ийн “Эрдэм” сонинд лекцийн тухай мэдээ материалуудыг нийтлүүлсэн.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ:90</p> <p>4.6. Иргэдэд бизнес эхлүүлэх, аж ахуй эрхлэх санаачилгыг идэвхжүүлэх, гарааны компанийг дэмжих;</p> <ul style="list-style-type: none"> ❖ Аж үйлдвэрийн яамнаас Монгол Улсад гарааны бизнес, энтрепренёршипын таатай орчин-экоосистемийг бий болгох, иргэд, аж ахуйн нэгжүүдийн энтрепренёрлэг сэтгэлгээ, урам зоригийг өдөөх, тухайн талбар дахь ололт, амжилтыг тэмдэглэх зорилгоор “Дэлхийд өрсөлдөх гарааны бизнесийн хөгжил өөд” чуулганыг 2015 онд 2 дахь удаагаа зохион байгуулсан. ❖ Стартап Монголиа ТТБ залуучуудад зориулан 2015 оноос хойш Startup weekend, Design thinking, Startup Grind, Drink Entrepreneurs, Startup Next зэрэг нийт 24 төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийт арван мянга гаруй залуучууд Стартап Монголиа ТТБ-тай хамтран ажилласан бөгөөд нийт 200 гаруй стартап компаниуд бизнесийн зөвлөх үйлчилгээ авснаас 100 гаруй нь үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн 20 компани нь шинээр хөрөнгө оруулалт хийж амжилттай ажиллаж байна. ❖ “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл” Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр 2016-2019 онд хэрэгжиж эхэлсэн. Төсөлд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, ХХААХҮЯ, ШУТИС, мэргэжлийн холбоодын төлөөллүүд хамтран иргэдэд бизнес эхлүүлэх, аж ахуй эрхлэх санаачилгыг идэвхжүүлэх, гарааны компанийг дэмжин ажиллаж байна. Өмнөговь, Баянхонгор, Баянөлгий, Ховд, Завхан, Говьалтай аймаг, Хан уул, Баянгол дүүрэгт төсөл тус тус хэрэгжиж байгаа. <p style="text-align: right;">Үнэлгээ:70</p> <p>4.7. Жижиг, дунд үйлдвэрт зориулсан зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх;</p> <p>бизнес-инкубатор төвийг аймаг бүрт байгуулах, үйл ажиллагааг нь дэмжих.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Эдийн засгийн хөгжлийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Хөдөлмөрийн сайд нарын хамтарсан 2013 оны 17, А/32, 38, А/30 дугаар тушаалын хүрээнд “Сум төсөл”-д ажлын хэсэг гарган ажиллаж 21 аймаг, 9 дүүрэгт байгуулах бизнес инкубатор төвүүдийн судалгааг хийсэн ба уг судалгаагаар сумын хүн амын тооноос хамааруулан (ө.х аймгийн төв, 5000-аас дээш хүн амтай сум, 3000-5000 хүн амтай сум, 3000 хүртэлх хүн амтай сум) ангилан, ангилал тус бүрд баригдах
--	--	--

		<p>“Ахуйн үйлчилгээний төв”, “Бизнес инкубатор төв”, “Ахуйн үйлчилгээ, бизнесийг дэмжих төв”-ийн зураг төсвийг хийж гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, бизнес инкубаторыг аймаг бүрт байгуулахаар 2014-2018 оны хөрөнгө оруулалтын төсөлд саналаа тусган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> ❖ Бизнес инкубацийн үйлчилгээнд Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвөөс зарлагдсан тендерт 19 Бизнес инкубаторын төв шалгарч нийт 672 495 000 төгрөгийн санхүүжилт авсан. Үүнээс 178 иргэн 176 265 501 төгрөгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, түрээсийн байрны хөнгөлөлт авсан. 141 иргэн, аж ахуй нэгж 155 552 604 төгрөгийн тоног төхөөрөмжийн түрээсийн хөнгөлөлтийг эдэлсэн байна. Борлуулалтын сүлжээ, түншлэлийн харилцаа холбоо тогтооход 153 иргэн, аж ахуй нэгжид 158 237 334 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Үзэсгэлэн яармаг оролцоход 145 иргэн, аж ахуй нэгжид 124 382 209 төгрөгийн дэмжлэг, 149 иргэн, аж ахуй нэгжид 58 057 352 төгрөгийн зөвлөх үйлчилгээний дэмжлэгийг тус тус үзүүлсэн. ❖ 2015 онуудад Инкубацийн үйлчилгээнд санхүүжилтийн эх үүсвэр тусгагдаагүй тул тодорхой үйл ажиллагаанууд хийгдээгүй. ❖ 2016 оны инкубацийн үйлчилгээнд 100 гаруй иргэн, аж ахуйн нэгж бойжигдож, 3000 гаруй иргэн, аж ахуй нэгжид /үүнээс 2400 иргэн, 600 аж ахуй нэгж/ сургалтын үйлчилгээ үзүүлсэн. ❖ 2015 оны төсвийн тухай хуулиар Аж үйлдвэрийн сайдын багцад батлагдсан Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/, Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/, Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/ арга хэмжээг Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн төвлөрүүлэн захирагчид эрх шилжүүлэн, үндсэн гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулж, гэрээнд заасан хугацаанд ажлыг дуусгах, гүйцэтгэлд хяналт тавих, барилга байгууламжийг ашиглалтанд хүлээн авах ажлыг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгосон. Дээрх хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдийн ажлын гүйцэтгэл Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв /Баянхонгор, Баянхонгор сум/-81%, Худалдааны төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/-100%, /, Ахуй үйлчилгээний төвийн барилга /Ховд, Жаргалант сум/-100%, Хүнс, барааны худалдааны төв /Хөвсгөл, Мөрөн сум/-70%-тай байна. Дээрхи 4 төвийн арга хэмжээг Төсвийн хуулийн 14.4 дэх заалтын дагуу Аж үйлдвэрийн сайдын тушаалаар төсвийн төвлөрүүлэн захирагчид хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэн, 1360,8 сая төгрөгийн гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжилтийг олгосон байна. ❖ Аймаг бүрт орон нутгийн, хувийн, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дэргэдэх 26 инкубатор төв үйл ажиллагаа явуулж, төвүүд үйлдвэрлэлийн байрыг хөнгөлөлттэй үнээр түрээслүүлж, бизнесийн сургалт зохион байгуулж, бизнесийн зөвлөх үйлчилгээг үзүүлж байна. ❖ Улсын 5 төв болох Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд, Говь-алтай, Завхан, Дархан-уул аймгуудад төвүүд санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтай, тэдгээрийн хууль эрхзүйн орчин байхгүйгээс Говь-алтай, Завхан, Баянзүрх дүүргийн Бизнес инкубатор төвүүдийн үйл ажиллагаа зогссон. Эдгээр 5 төвүүдийг “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бизнес инкубатор төв” аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан 2015 онд 3 сард Засгийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр оруулсан боловч
--	--	---

		<p>Хөдөлмөрийн яам, Сангийн яамтай зөвшилцөөгүй улмаас шийдвэрлэгдээгүй. Одоогийн байдлаар эдгээр 5 төв Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяанд байгаа болно.</p> <p>❖ Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдээс Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банктай хамтран ЖДҮ-ийн ажиглалт судалгааг түүврийн аргаар 2014, 2015 онд нийт 3000 иргэн, ААН-ээс авсан. Судалгаанд зөвлөх үйлчилгээг хир ашигладаг талаар асуулга оруулсан. Судалгаагаар Улаанбаатар хотод 2014 онд 84 хувь ашиглагдаг гэсэн бол 2015 онд 94 хувь болж нэмэгдсэн байна. Гэвч орон нутагт 2014 онд 88,5 хувьтай байсан бол 2015 онд 84,5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Судалгаанаас харахад орон нутагт зөвлөх үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн байгууллага хомс, мэдээлэл тааруу байгаатай холбоотой гэж үзэж байна.</p> <p>❖ Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих” төслийн хүрээнд 2012-2016 онд нийт 245 компанид зөвлөх үйлчилгээ үзүүлсэн.</p> <p style="text-align: right;">Үнэлгээ:100</p>																																																																																																																	
4 дүгээр Зорилтын дундаж үнэлгээ: /хувиар/ 92,8																																																																																																																			
<p>Зорилт 5. Санхүүгийн эх үүсвэрийн нэмэгдүүлэх хүртээмжийг хангах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:</p> <p>Хүрэх үр дүн: Жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээл, тоног төхөөрөмжийн лизинг, батлан даалтын үйлчилгээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо өссөн байна.</p>	<p>5.1. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэмжээнд хүргэн бүрдүүлэх;</p> <p>❖ Улсын Их хурлаас 2011-02-10-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль баталж уг хуулиар хөгжлийн банкны үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож өгсөн байна. Хуулийг хэрэгжүүлэх хүрээнд:</p> <p>❖ 2012-04-25-ний өдрийн 138 тогтоолоор дугаар Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтод хөтөлбөрийн хүрээнд бүсийн тулгуур төв, аймаг, орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар ажлын байр бий болгоход шаардагдах 50.0 (тавин) тэрбум төгрөгийн санхүүжилтийг зохих журмын дагуу шийдвэрлэхийг Хөгжлийн банкд даалгасан.</p> <p style="text-align: center;"><i>Хөгжлийн банкны 50 тэрбум төг санхүүжилтээр хөнгөлөлттэй зээл авсан иргэн, аж ахуй нэгж /салбараар/</i></p>	<table border="1" data-bbox="638 1321 1492 1742"> <thead> <tr> <th rowspan="2">Чигэлэл</th> <th rowspan="2">Төслийн тоо</th> <th rowspan="2">Зээл /сая.төг/</th> <th colspan="2">Үйл ажиллагаа</th> <th colspan="2">Ажлын байр</th> </tr> <tr> <th>өргөтг өсөн</th> <th>шинээр</th> <th>шинэ</th> <th>хадгалсан</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Барилга</td> <td>33</td> <td>2513.5</td> <td>23</td> <td>10</td> <td>776</td> <td>281</td> </tr> <tr> <td>Био</td> <td>3</td> <td>980.0</td> <td>2</td> <td>1</td> <td>41</td> <td>35</td> </tr> <tr> <td>Газар тариалан</td> <td>7</td> <td>2560.0</td> <td>3</td> <td>4</td> <td>159</td> <td>72</td> </tr> <tr> <td>Зоорь</td> <td>5</td> <td>4236.6</td> <td>3</td> <td>2</td> <td>106</td> <td>59</td> </tr> <tr> <td>Мал аж ахуй</td> <td>15</td> <td>3145.0</td> <td>11</td> <td>4</td> <td>169</td> <td>99</td> </tr> <tr> <td>Хөнгөн үйл.</td> <td>26</td> <td>5404.5</td> <td>20</td> <td>6</td> <td>281</td> <td>229</td> </tr> <tr> <td>Худалдаа, үйлчилгээ</td> <td>13</td> <td>1689.0</td> <td>6</td> <td>7</td> <td>162</td> <td>67</td> </tr> <tr> <td>Хүнсний үйл.</td> <td>22</td> <td>9836.5</td> <td>14</td> <td>8</td> <td>392</td> <td>282</td> </tr> <tr> <td>Бусад</td> <td>27</td> <td>8604.0</td> <td>16</td> <td>11</td> <td>454</td> <td>166</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>151</td> <td>48969.1</td> <td>98</td> <td>53</td> <td>2540</td> <td>1290</td> </tr> </tbody> </table> <p style="text-align: center;">/байршлаар нь /</p> <table border="1" data-bbox="638 1769 1492 1960"> <thead> <tr> <th rowspan="2">Чигэлэл</th> <th rowspan="2">Төслийн тоо</th> <th rowspan="2">Зээл /сая.төг/</th> <th colspan="2">Үйл ажиллагаа</th> <th colspan="2">Ажлын байр</th> </tr> <tr> <th>өргөтгөсөн</th> <th>шинээр</th> <th>шинэ</th> <th>хадгалсан</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Улаанбаатар</td> <td>117</td> <td>39166.1</td> <td>75</td> <td>42</td> <td>1986</td> <td>1019</td> </tr> <tr> <td>Орон нутаг</td> <td>34</td> <td>9803.0</td> <td>23</td> <td>11</td> <td>554</td> <td>271</td> </tr> <tr> <td>Нийт</td> <td>151</td> <td>48969.1</td> <td>98</td> <td>53</td> <td>2540</td> <td>1290</td> </tr> </tbody> </table> <p><i>Мэдээллийн эх үүсвэр: Жижиг дунд, үйлдвэрийг хөгжүүлэх сан</i></p> <p>❖ Засгийн газрын 138 дугаар тогтоолын хэрэгжүүлэх хүрээнд 2016 оны байдлаар нийт 151 иргэн, аж ахуй нэгжид 48,9 тэрбум төгрөгийн зээл олгож, 98 иргэн, аж ахуй нэгж үйл ажиллагаагаа</p>	Чигэлэл	Төслийн тоо	Зээл /сая.төг/	Үйл ажиллагаа		Ажлын байр		өргөтг өсөн	шинээр	шинэ	хадгалсан	Барилга	33	2513.5	23	10	776	281	Био	3	980.0	2	1	41	35	Газар тариалан	7	2560.0	3	4	159	72	Зоорь	5	4236.6	3	2	106	59	Мал аж ахуй	15	3145.0	11	4	169	99	Хөнгөн үйл.	26	5404.5	20	6	281	229	Худалдаа, үйлчилгээ	13	1689.0	6	7	162	67	Хүнсний үйл.	22	9836.5	14	8	392	282	Бусад	27	8604.0	16	11	454	166	Нийт	151	48969.1	98	53	2540	1290	Чигэлэл	Төслийн тоо	Зээл /сая.төг/	Үйл ажиллагаа		Ажлын байр		өргөтгөсөн	шинээр	шинэ	хадгалсан	Улаанбаатар	117	39166.1	75	42	1986	1019	Орон нутаг	34	9803.0	23	11	554	271	Нийт	151	48969.1	98	53	2540	1290
Чигэлэл	Төслийн тоо	Зээл /сая.төг/				Үйл ажиллагаа		Ажлын байр																																																																																																											
			өргөтг өсөн	шинээр	шинэ	хадгалсан																																																																																																													
Барилга	33	2513.5	23	10	776	281																																																																																																													
Био	3	980.0	2	1	41	35																																																																																																													
Газар тариалан	7	2560.0	3	4	159	72																																																																																																													
Зоорь	5	4236.6	3	2	106	59																																																																																																													
Мал аж ахуй	15	3145.0	11	4	169	99																																																																																																													
Хөнгөн үйл.	26	5404.5	20	6	281	229																																																																																																													
Худалдаа, үйлчилгээ	13	1689.0	6	7	162	67																																																																																																													
Хүнсний үйл.	22	9836.5	14	8	392	282																																																																																																													
